

## МУЗЕЙН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛБАР БОЛОВСРУУЛАХ АРГА ЗҮЙ

*Музейн олон нийт боловсролын ажилд тайлбарт аялал, лекц яриа, нэрэмжит /ойн/ үдэшлэг, өдөрлөг, сургалт семинар, зөвлөлгөөн зэргийг багтаана.*

*Аливаа музейн тайлбарт аялал зохион байгуулахад түүний зэрэглэл, бүтэц зохион байгуулалтыг харгалзан нэн түрүүн анхаарах арга зүйн асуудал нь тухайн сэдвийг тогтооход оршино. Сэдвийн хүрээнд аялах дэлгэрэнгүй төлөвлөгөө боловсруулж, түүнийхээ дагуу эрдэм шинжилгээ, судалгааны материал, судлаачдын ажил бүтээлээс гэх мэт гарын авлагыг бүрдүүлж бэлтгэнэ. Тайлбарт аялалын зорилго, сэдэв, хамрах хүрээтэй уялдуулан үзүүллэгийг тайлбарлах дэс дараалал тодорхойлогддог.*

Тайлбарт аяллын олон хэлбэр

Тайлбарт аялалыг түүний агуулга болон хаана явуулахаас хамаарч доорх байдлаар ангилна:

-музейн үзмэр, сан хөмрөгийн тайлбарт аялал / музейн танхимууд дахь үзмэр үзүүлэг, түүнчлэн сан хөмрөгийн өрөө байруудад эд өлгийн зүйлсийн хадгалагдах орчинг тайлбарлан үзүүлдэг/

-музейн гаднах тайлбарт аялал /тайлбарт аялал нь зөвхөн музейн сан хөмрөг болон барилга байгууламжийн онцлогийг олон нийтэд таниулан мэдүүлэх, сурталчлах хэлбэр бус, музейгээс гаднах тухайн газар нутгийн онцлог, түүхэн үйл явдал, он цагийн гэрч зүйлсийг ч тайлбарлах үйл ажиллагаа юм./

-хосолсон буюу цогц хэлбэрийн тайлбарт аялал /музейн үзүүлэг ба сан хөмрөгийг музейн гаднах түүх дурсгалын өвтэй уялдуулан тайлбарлах/

### **Тайлбарт аялалын зорилго:**

-ерөнхий боловсролын

-сургалтын

-тусгай

-хичээл-тайлбарт аялал

### **Тайлбарт аялалд хамрагдаж буй хүмүүсийн:**

-насны ангиллаар

-нийгмийн анги давхаргаар

-амьдардаг газрын харъяаллаар

- холимог гэж гэж тус тус хуваадаг.

Тайлбарт аялалд бэлтгэх нь.

Тайлбарт аялалд бэлтгэх үйл явц нь хэд хэдэн шат дараалалтай байдаг.

1. Зорилгыг тодорхойлох: тайлбарт аялалын зорилгыг тодорхойлох буюу ямар зорилгоор түүх соёлын энэхүү дурсгалт өвийг үзүүлж байгаа тухай тайлбарлагч өөрийн тайлбарт тусгаж ярих хэрэгтэй болно.

2. Сэдвийг сонгох. Сонгосон сэдвийн дагуу тайлбарын ерөнхий агуулгыг боловсруулна.

3. Холбогдох ном, зохиол, өгүүллэг, судалгааны бүтээлүүдийг сонгон цуглуулж жагсаалт гаргах. Уг жагсаалтад бүтээлийн зохиогч, нэр, хэвлэгдсэн он, бүлэг, хэсэг, хуудсыг бүрэн заах хэрэгтэй.

4. Музей, архив зэрэгт хадгалагдаж байгаа бусад эх сурвалжуудыг тодорхойлох

5. Ном зохиол, архивын холбогдох материал болон статистикийн судалгаа зэргийг үзэж судална. Тайлбарлах зүйлсийн тухай тэмдэглэл хөтөлж, баримтын түүвэр, хуулбарыг хийнэ.

6. Тухайн тайлбар хийх гэж буй музейн үзүүлэг, сан хөмрөгтэй сайтар танилцсан байх.

7. Тайлбарлах зүйлийн онцлогийг харгалзан сонгон судлах. Үзүүлэг эд зүйлсийн ач холбогдлыг энэ үе шатанд тодорхойлсон байна. Түүнийг тодорхойлохын тулд доорх зүйлсийг харгалзан үзэж болно.

А) Танин мэдэхүйн ач холбогдол

Б) Үзмэр эд зүйлсийн танигдсан байдал

В) Үзмэр эд өлгийн ховор содон шинж байдал

Г) Үзмэр эд өлгийн үзэмж, анхаарал татах байдал

Д) Үзмэр эд өлгийн хадгалагдсан байдал

Е) Үзмэр эд өлгийн байршил / үзэгдэх орчин/

8. Үзэгчдийн ая тухыг бодолцон аялах чиглэлийг тогтоох: автобусны эсвэл явган аялал: Аялалын маршрутыг 1) он цагийн дарааллаар, 2) сэдэвчилсэн дарааллаар, 3) он цагийн дарааллыг сэдэвчилсэнтэй хослуулсан /тойм хэлбэр/-аар зохион байгуулсан байж болно.

9. Тойрон аялах маршрут

10. Тодорхой материалаас бүрдсэн хяналтын эх-текстийг бэлтгэх: 2 төрлийн хяналтын эх бий: Эхний хэлбэр нь бүхий л тайлбарлагчдад зориулагдсан байх бөгөөд хоёр дахь хэлбэр нь - нэг тайлбарлагч өөрийн үгээр бэлтгэсэн текст байна.

11. Тайлбарлагчийн “гар цүнх”-ийг бүрдүүлэх: тайлбарлагчийн “гар цүнх” нь тайлбарт аялалын үед үзэгчийн зүгээс гарч болзошгүй асуултын хариу болон үзмэр үзүүлэгтэй холбоотой бусад нэмэлт мэдээллийг агуулсан байх ёстой. Мөн тайлбар хийх явцад үзмэр үзүүлэгтэй холбоотой нүдэнд харагдахгүй төсөөллийг үзэгчдэд хүргэхэд хэрэглэнэ.

12. Арга зүйг тогтоох. Тайлбар хийх арга зүй нь үзэгчдийн бүрэлдэхүүний онцлог, тухайн цаг үе, үзүүлэгийн онцлог зэргээс хамааран харилцан адилгүй байдаг.

13. Тайлбарын арга зүйг боловсруулах. Тухайн аялалыг хэрхэн зохион байгуулах, дурсгалт зүйлсийг хэрхэн тайлбарлах, аялалыг амжилттай сонирхолтой болгохын тулд ямар арга барилыг баримтлах зэргийг тодорхойлон тусгасан баримт бичгийг боловсруулах хэрэгтэй. Энэхүү баримт нь тухайн байгууллагын бичиг баримт болон хадгалагдаж байна.

Тайлбарт аялал хийх арга зүйн боловсруулалт

Аялалын маршрут	Зогсолт Хаана зогсох	Үзмэр	Үргэлжлэх хугацаа	Дэд сэдвийн нэр, гол асуудлууд	Зохион байгуулалтын талаарх заавар	Арга зүйн заавар
1	2	3	4	5	6	7

14. Тайлбарын текст эхийн талаарх болон тайлбар хийх арга зүйн боловсруулалттай танилцсан арга зүйчийн дүгнэлт,

15. Туршилтын тайлбарт аялал

16. Тайлбарт аялалыг батлах

**Тайлбарлагч тайлбарт аялалын шинэ сэдэв боловсруулахдаа нь хяналтын эх-текст, арга зүйн боловсруулалт зэргээ тухай бүрд нь шинэчлэн баяжуулж байна.**

**Тайлбарт аялал гэдэг нь танин мэдэхүй, боловсрол, судалгаа шинжилгээний болон хүмүүжлийн зорилгоор бүлэг хүмүүст /нэг дор 25 хүртлэх/ түүх соёлын өв санг тайлбарлагчийн удирдлагаар танилцуулах явдал юм.**

**Ашигласан материал:**

А.М.Горькийн нэрэмжит Уралын улсын их сургууль

“Музейн боловсролын ажлын арга зүйн зөвлөмж” Екатеринбург. 1998.

Орчуулсан: **М. ЦЭРМАА**

Музей судлаач

Музейн мэдээлэл. МҮМ-н мэргэжил-арга зүй, мэдээллийн сэтгүүл.

2009.XII.№ 02. Тал. 17.